


## ИНФЛЯЦЫН ТҮВШИН, сараар (%)

● 2016 ● 2017 ● 2018 ● 2019.I-VIII




Инфляцын түвшин 2016 онд 1.3 хувь, 2017 онд 6.4 хувь, 2018 онд 8.1 хувьтай гарч байсан бол 2019 оны 8 дугаар сард 8.9 хувьтай гарч 2018 оноос 0.8 пунктээр өссөн байна.

### ИНФЛЯЦЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ТҮВШИН


0.7 | 4.3 | 6.8 | 7.6  
2016 | 2017 | 2018 | 2019.I-VIII

### ИНФЛЯЦЫН ЖИЛИЙН ТҮВШИН



## БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГЭЭР


2019.VIII



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.3 хувь, орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

## БҮСЭЭР

2019.VIII



2019 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод инфляц 10.5 хувьтай гарсан нь бусад бүсээс хамгийн өндөр үзүүлэлт байсан бол төвийн бүсийн инфляцын түвшин 6.2 хувьтай гарсан нь хамгийн бага үзүүлэлт нь байлаа.



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН 2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

2019 он



## **АГУУЛГА**

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
ИНФЛЯЦ.....	4

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 8 дугаар сард .....	4
Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 8 дугаар сард.....	5
Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 8 дугаар сард.....	6
Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, бараа, үйлчилгээний бүлгээр, улс, бүсээр, хувиар, 8 дугаар сард.....	8
Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар, жил бүрийн 8 дугаар сард.....	9

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, 2016-2019 он, жил бүрийн 8 дугаар сард.....	5
Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь.....	7
Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 8 дугаар сард (өмнөх сар=100%).....	7
Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувь, (өмнөх оны 12 дугаар сар = 100%).....	8
Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 8 дугаар сард.....	9
Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	9
Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	10
Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	10
Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 сар=100%).....	11
Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	11

## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

### Инфляц

Инфляцын түвшин 2016 оны 8 дугаар сард -0.1 хувь, 2017 оны 8 дугаар сард 5.0 хувь, 2018 оны 8 дугаар сард 6.0 хувьтай байсан бол 2019 оны 8 дугаар сард 8.9 хувь болж өмнөх оноос 2.9 пунктээр буурсан байна.

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 8 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 VIII	2017 VIII	2018 VIII	2019 VIII
<b>Ерөнхий индекс</b>	<b>100</b>	<b>-0.1</b>	<b>5.0</b>	<b>6.0</b>	<b>8.9</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	-0.8	1.5	1.4	3.4
Согтууруулах ундаа, тамхи	4.4	0.0	0.1	0.3	0.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	0.4	0.4	0.6	1.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	-0.1	0.5	1.0	1.2
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	0.1	0.1	0.3	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	0.1	0.2	0.5	0.3
Тээвэр	14.4	-0.3	1.3	0.8	0.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	0.0	0.0	0.3	0.4
Боловсролын үйлчилгээ	4.8	0.2	0.3	0.3	0.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	0.0	0.0	0.2	0.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	0.1	0.3	0.3	0.3

Инфляц 2019 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 8.9 хувьтай гарлаа. Үүнийг бүлгүүдийн оролцооны түвшингээр авч үзвэл 3.4 нэгж буюу (38.3 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгээс, 1.5 нэгж буюу (16.8 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгээс, 1.2 нэгж буюу (13.3 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. 2018 оны 8 дугаар сард хүнсний бараа, ундаа, усны бүлэг инфляцад 23.9 хувиар нөлөөлж байсан бол 2019 оны 8 дугаар сард 38.3 хувь болж 14.4 пунктээр өссөн байна.

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 8 дугаар сард



Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 8 дугаар сард

Үзүүлэлт	2016 VIII		2017 VIII		2018 VIII		2019 VIII	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
<b>Ерөнхий индекс</b>	<b>-0.1</b>	<b>100.0</b>	<b>5.0</b>	<b>100.0</b>	<b>6.0</b>	<b>100.0</b>	<b>8.9</b>	<b>100.0</b>
Импортын барааны нөлөө	0.2	-157.0	2.6	51.5	2.4	39.5	2.9	33.3

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг.

2019 оны 8 дугаар сард инфляц 8.9 хувь гарсны 2.9 нэгж буюу 33.3 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Энэ нь 2018 оны 8 дугаар сартай харьцуулахад нөлөөлөл нь 6.2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2019 оны 8 дугаар сард


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019 VII 2018 VII	2019 VII 2018 XII	2019 VII 2019 VI
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>107.4</b>	<b>104.8</b>	<b>99.9</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	109.5	113.9	99.2
Согтууруулах ундаа, тамхи	4.4	103.0	102.3	100.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	109.7	104.0	100.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	109.1	98.8	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	104.2	102.0	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	108.1	102.5	100.4
Тээвэр	14.4	102.9	98.5	99.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	101.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	115.6	110.6	100.0
Боловсролын үйлчилгээ	4.8	105.6	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	109.4	107.1	101.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	105.9	103.4	100.2

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.3 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 32.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 16.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 5.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь (мах, махан бүтээгдэхүүн 32.8 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.3 хувиар өсөхөд , орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 9.7 хувь, зочид буудал зоогийн газрын бүлгийн үнэ 2.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх сараас Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Архангай, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь, Төв, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Улаанбаатар хотод 0.2-1.0 хувиар өсөж, Дундговь аймагт өөрчлөлтгүй бусад аймагт 0.1-1.1 хувиар буурсан байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард Баянхонгор аймагт 1.1 хувиар буурч, Говь-Алтай аймагт 1.0 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, 2019 оны 8 дугаар сард (өмнөх сар= 100%)





Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2019 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.4 хувь, өмнөх оны эцсээс 6.0 хувь, өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 15.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 14.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 14.9 хувь, амралт, эм, тариа, эмнэлгийн үйлчлэл бүлгийн дүнгээрээ 7.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 14.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.4 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 7.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн дүнгээрээ 2.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод 2019 оны 8 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 33.1 хувь буюу 114 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 12.5 хувь буюу 43 бараа, үйлчилгээний үнэ буурч, 54.4 хувь буюу 187 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 48 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, хувиар, (өмнөх оны 12 дугаар сар = 100%)



2019 оны 8 дугаар сард мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны эцсээс 32.8 хувиар өссөн байна. Үүнд үхрийн махны үнэ 34.8 хувь, хонины ястай махны 40.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.




■ Мах, махан бүтээгдэхүүн ■ Бусад бараа, үйлчилгээ

Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, 2019 оны 8 дугаар сард


2019 оны 8 дугаар сард оны эхнээс инфляц 5.4 хувиар өссөн бөгөөд 2.4 нэгж буюу 45.4 хувь нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн цул махны дундаж үнэ 2019 оны 8 дугаар сард 13 873 төгрөгийн үнэтэй байгаа нь 2016 оны 8 сараас 60.1 хувь, 2017 оны 8 сараас 62.9 хувь, 2018 оны 8 сараас 39.0 хувиар өссөн байна.

Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн ястай махны дундаж үнэ 2019 оны 8 дугаар сард 11 537 төгрөгийн үнэтэй байгаа нь 2016 оны 8 сараас 52.7 хувь, 2017 оны 8 сараас 51.3 хувь, 2018 оны 8 сараас 33.3 хувиар өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа хонины ястай махны дундаж үнэ 2019 оны 8 дугаар сард 9 701 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд 2016 оны 8 сараас 58.0 хувь, 2017 оны 8 сараас 51.8 хувь, 2018 оны 8 сараас 39.0 хувиар өссөн байна.

Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2016-2019 он (өмнөх оны 12 сар=100%)



2019 оны 8 дугаар сарын байдлаар бензин, түлшний үнэ өмнөх оны эцсээс 2.4 хувиар буурсан бол өмнөх сараас 0.5 хувиар өсжээ.

Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр



2019 оны 8 дугаар сард АИ-92 бензиний дундаж үнэ 1 833 байгаа нь 2016 оны 8 сараас 20.6 хувь, 2017 оны 8 сараас 12.4 хувь, 2018 оны 8 сараас 0.7 хувиар тус тус өссөн байна.